

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ


Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +8.5%, 2020 онд: 7.5%

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%
Инфляци: 2019 онд: +7.1%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА


Төсвийн тэнцэл 4-р сарын байдлаар 286 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 61.1 хувиар, зарлага 63.4 хувиар тус тус буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 286 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 188.3 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.



Ам.долларын ханш өмнөх сараас 2 төгрөгөөр буурав.

Дөрөвдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 240 төгрөг буюу 10 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 2 төгрөг буюу 0.09 хувиар нэмэгдэж 2634.93 төгрөг болов. 3-р сард гадаад валютын нөөц 3.6 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеэс 22.7 хувь нэмэгдсэн байна.




Инфляцийн түвшин 7%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 4-р сарын байдлаар өмнөх сараас 1 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар, оны эхнээс 2.8 хувь өсөв. Хүнсний бараа 7 хувиар тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 20.4 өссөн бол цахилгаан, хийн түлшний үнэ 8.9, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний үнэ 9.5 хувь өссөн нь нөлөөлжээ.



Гадаад худалдааны тэнцэл 745 сая.ам доллар болов.

2019 оны дөрөвдүгээр сарын байдлаар нийт барааны эргэлт 4278 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 18.1 импорт өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 745 сая ам.долларын ашигтай гарлаа.



4-Р САРЫН ОНЦЛОХ: ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ



Эх сурвалж: www.1212.mn

ДНБ 2019 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 3.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 18,338 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 8.6 хувиар өсөв. ДНБ-ий 8.6 хувиар өсөхөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 127.7 (8%) тэрбум төгрөг (бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 52.2 (13.9%) тэрбум төгрөг), аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 124.9 (11.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Статистикийн хорооны тооцооноос харахад өнгөрсөн оны мөн үед эдийн засгийн өсөлт (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 3.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 279.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж эдийн засгийн өсөлт 6% болсон.

Улирлын нөлөөллийг арилган тооцооноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2019 оны 1 дүгээр улиралд өмнөх улирлаас 0.1 хувиар өслөө. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2019 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 7.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 (15.6%) их наяд төгрөгөөр өслөө. Харин эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 3.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 285.8 (8.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Уг өсөлтөд бараа, үйлчилгээний экспорт 840.5 (26.0%) тэрбум төгрөг, хөрөнгийн нийт хуримтлал 403.5 (29.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

САРЫН ОНЦЛОХ

ДЭЛХИЙН БАНКНААС “ЗҮҮН АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ” ТАЙЛАН ГАРАВ.

- Дэлхийн банкны Улаанбаатар дахь суурин төлөөлөгчийн газраас “Зүүн Ази, Номхон далайн эдийн засгийн тойм” тайлангийн үр дүнг танилцуулав. Үүнд: Монгол Улсын эдийн засгийн өсөлт (2016 онд 1.4 хувь, 2017 онд 5.4 хувь) 2018 онд төсөөллөөс давж, уул уурхайн бүтээгдэхүүн болон гадаадын шууд хөрөнгө оруулалтаас шалтгаалан 6.9 хувьд хүрчээ. Хувийн хэрэглээ, уул уурхайн болон аж үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтаас хамаарч эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв 2019 он болоод цаашид өөдрөг байх төлөвтэй байна. Эдийн засгийн төлөв эерэг байхаас шалтгаалан ядуурал буурах хандлагатай. Улс төрийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн огцом хэлбэлзэл, хил дээрх логикийн хүндрэл, банкны салбарт хийгдэж буй шинэчлэлийн хэрэгжилт удаашрах эрсдэл болон мөнгө угаахтай холбоотой арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх зэрэг асуудалд сайтар анхаарахыг Дэлхийн банкаас зөвлөв.

АЛТ ХУДАЛДАН АВАЛТ 10 ХУВИАР НЭМЭГДЖЭЭ.

- Монголбанк өнгөрсөн дөрөвдүгээр сард 1.1 тонн алт худалдан авчээ. Энэ нь өнгөрсөн оныхоос 101 кг-аар илүү буюу Төвбанкны худалдан авсан алт 10 хувиар нэмэгдсэн дүн юм. Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 9 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 3 кг алт худалдан авчээ. Худалдан авалт ийнхүү өссөнийг УИХ-ын ээлжит бус чуулганаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг таван хувь болгосонтой холбон тайлбарлаж байна. Тодруулбал, УИХ-ын энэ оны гуравдугаар сарын 26-ны ээлжит бус чуулганаар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, алтны ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг таван хувь болгосон. Дөрөвдүгээр сарын байдлаар нэг грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 108.757.36 төгрөг байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 4-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 4-р сар 2019 он, Монголбанк
3. www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn